

# МОНГОЛ УЛС

## 2014 оны байдлаар:

Хүн ам \сая\	2,995
ДНБ \тэрбум ам.доллар\	12,0
Нэг хүнд ноогдох ДНБ \ам. доллар\	4055
Нэг хүнд ноогдох \ам. доллар, PPP\	
Ядуурлын түвшин \2012\	27.4
Ядуурлын түвшин \2.50 ам. доллар\	
Орлогын хуваарьлалт, хэрэглээний коэффициент \2012\	33.8
Дундач наслалт	69.1
Бага сургуулийн хамралт	97

*Гадаад эдийн засгийн таагүй орчин, эдийн засгийн тогтворгүй бөгөөд тэнцвэргүй байдлаас шалтгаалан Монгол улсын эдийн засгийн өсөлт саарч байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт төдийлөн сэргэхгүй байгаа, улсын гадаад валютын нөөц багассан зэрэг нь эдийн засгийн гадаад секторын эмзэг байдалд сөргөөр нөлөөлж байна. Гадаад секторын эмзэг байдлаас шалтгаалсан эдийн засагт учирч болзошгүй сөрөг нөлөөллүүдээс зайлсхийх арга хэмжээг бодлого боловсруулагчид яаралтай авах нь чухал болоод байна. Төсвийн болон эдийн засагт шаардлагатай зарим тохиргоотой холбоотойгоор ирэх жилүүдэд ядуурлын түвшин үргэлжлэн буурах нөхцөл хумигдахаар байна.*

## Эдийн засгийн сүүлийн үеийн нөхцөл, байдал

Хөрөнгө оруулалтын огцом бууралтаас шалтгаалан 2013 онд 11.6 хувийн өсөлттэй гарч байсан эдийн засгийн өсөлт 2014 онд 7.8 хувь болж буурав. Өнгөрсөн онд хөрөнгө оруулалт 34.5 хувь болж буурсан бол эцсийн хэрэглээний өсөлт мөн саарсан. Уул, уурхайн бус салбарын өсөлт 2013 онд 9.8 хувиар өсч байсан бол 2014 онд 3.6 хувь болж буураад байна. Харин Оюу толгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл 34 хувиар нэмэгдсэнээс шалтгаалан уул уурхайн салбарын өсөлт 24.2 хувьтай гарав.

Урсгал дансны алдагдал 2014 оны эцэст ДНБ-ий 8.2 хувьтай тэнцэж, өмнөх онуудад дундажаар 24.4 хувьтай гарч байсантай харьцуулахад огцом буурсан бөгөөд энэ нь нэг талдаа зэсийн баяжмалын экспорт өссөн, нөгөө талдаа импортын хэмжээ саарсантай холбоотой байв.

Төлбөрийн тэнцлийн алдагдал 2014 онд 427 сая ам.доллар болж, улсын гадаад валютын нөөц гурван сарын импортын хангахуйц түвшинд хүрэв. Төвбанкны Хятадын ардын банктай хийж буй төгрөг-юаны своп хэлцэл нь төлбөрийн тэнцлийн хүндрэл, улсын гадаад валютын нөөцийн бууралтыг сааруулах нөлөөг үзүүлж ирлээ. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрах дарамт 2014 онд үргэлжилсэн бөгөөд оны эцсийн байдлаар жилийн 13 хувиар суларчээ.

Төсвийн бодлого 2014 онд тэлсэн хэвээр хэрэгжсэн бөгөөд Хөгжлийн банкны зарцуулалтыг оруулж тооцсон нэгдсэн төсвийн алдагдал ДНБ-ний 11 хувьд хүрэв. Засгийн газраас Хөгжлийн банкаар дамжуулж олгогдсон, улсын төсвөөс эргэн төлөгдөх төсөл, хөтөлбөрүүдийг төсөвт нэгтгэх арга хэмжээг 2015 оны төсвөөс эхлэн хэрэгжүүлсэн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг 2018 он гэхэд ДНБ-ний 2 хувьд хүргэх, өрийн өнөөгийн үнэ цэнээр тооцсон хэмжээг (NPV) ДНБ-ний 40 хувьд хүргэн бууруулахаар төлөвлөөд байна.

Мөнгөний бодлого чангарах чиглэлд хэрэгжиж эхэлсэн. Төвбанкнаас бодлогын зарим бодлогын зээлүүдийн хэмжээгээ бууруулсан, бодлогын хүүгээ хоёр ч удаа өсгөн 13 хувьд хүргэсэн зэрэг нь мөнгөний бодлогын төлөв хатуурч байгаа илтгэж байна. Гэвч төвбанкнаас санхүүгийн бус салбарт олгосон зээлийн хэмжээ нь 2014 оны 4 дүгээр улирлаас өсч байгаа нь орон сууцны зээлээр барьцаалагдсан үнэт цаасыг Монголбанк худалдан авч байгаа болон компаниудад эх үүсвэрийн дэмжлэг үзүүлж байгааг илтгэж байна.

Ядуурлын түвшин 2010-2012 онд 11 хувиар буурч байсантай харьцуулахад 2013-2014 онд харьцангуй бага хэмжээгээр буурсан байх хандлага ажиглагдаж байна. 2010-2012 онд ядуурлын түвшин их хэмжээгээр буурсан нь иргэдэд хүний хөгжлийн сангаас мөнгөн тэтгэмж олгосон, ажил эрхлэлт, дундаж цалин өссөн нь голлон нөлөөлсөн. Хэдий тийм боловч уг иргэдэд мөнгө тараалт нь тодорхой бүлгийг зорилт болгоогүй, хэлбэлзэл өндөртэй уул, уурхайн салбарын орлогоос хамаарсан зэрэг нь уг хөтөлбөр нь тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, ядуурлыг бууруулах нөлөө нь зөвхөн түр зуурын шинжтэй байсныг хэлэхэд илүүдэхгүй биз.

### **Эдийн засгийн цаашдын төлөв**

Ойрын жилүүдэд эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарах төлөвтэй байна. Уул, уурхайн салбарын өсөлт гол эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах төлөвлөгөөтэй уялдан саарахаар байна. Уул, уурхайн бус салбарын өсөлт 2015 онд саарах ч харин хөрөнгө оруулалтын гол төслүүдтэй холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэж үзвэл 2016-2017 онд эргэн сэргэх төлөвтэй байна.



Урсгал дансны алдагдал 2015 онд өсөхөөр байгаа ба цаашид 2016-2017 онд ч эрдэс баялгын экспорт буурахтай холбоотойгоор улам бүр нэмэгдэх эрсдэлтэй байгааг анхаарах. Төлбөрийн тэнцэл 2015 онд алдагдалтай хэвээр байх төлөвтэй байгаа бөгөөд энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт төдийлөн сэргэхгүй байхаас голчлон шалтгаалж байгаа бөгөөд хэдий своп хэлцэл цаашид үргэлжлэхээр байгаа ч валютын нөөц болон төгрөгийн ханшинд ирэх дарамт хэвээр хадгалагдах эрсдэл байна.

Монгол улсын Их хурлаас 2 дугаар сард баталсан Макро бодлогын цогц өөрчлөлтийн хөтөлбөрт \МБЦӨХ\ эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээнүүдийг тусгасан. Уг хөтөлбөрт Хөгжлийн банкны төсвөөс эргэн төлөгдөх төсөл, хөтөлбөрүүдийг төсөвт нэгтгэх, Монголбанкны Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгогдсон төлөгдөөгүй байгаа зээлийг Засгийн газарт шилжүүлэх асуудлууд тусгагдсан. Мөн банкуудын хяналт, шалтгалтыг сайжруулах болон хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүд тусгагдсан.

Ядуурлыг бууруулах хамгийн гол хүчин зүйлүүд нь нийгмийн халамж, бодит цалингийн өсөлт болон ажил эрхлэлтийн өсөлт юм. Төсвийн орлого хумигдаж байгаа, нийгмийн халамжийг зохилтот болгох улс төрийн дэмжлэг хомс байгаа болон эдийн өсөлт саарахаар байгаагаас цаашид бодит цалин өсөх, ажил эрхлэлт нэмэгдэх боломж хомс байна.

**Зураг 1.** ДНБ-ний жилийн өсөлт: 2007-2014

**Зураг 2:** Хэрэглээний ялгаатай түвшингээр тооцосон хэрэглээний жилийн өсөлт: 2010-2012



## Тулгарч буй хүндрэл, сорилтууд

Эдийн засгийн цаашдын төлөв нь төлбөрийн тэнцлийн үргэлжилсэн хүндрэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын үргэлжилсэн бууралтаас ихээхэн хамаарахаар байна. Урсгал тэнцлийн өндөр алдагдал болон буурч буй валютын нөөцөөс улбаалан гадаад секторын эмзэг байдал үргэлжлэх хандлагатай байна. ГШХО төдийлөн сэргэхгүй байгаа, уул, уурхайн зах зээлийн цаашдын таагүй нөхцлөөс шалтгаалан эдийн өсөлт болон гадаад секторт ирэх дарамт хадгалагдах эрсдэлтэй байна. Гадаад эмзэг байдал нь өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн тэлэх бодлогоо хязгаарлах, улмаар хатууруулах шаардлагатай сануулж байгаа бөгөөд цаашид шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Төсвийн орлогын өөдрөг төсөөлөл болон Хөгжлийн банкны арилжааны зээлүүдээс шалтгаалан нэгдсэн төсвийн алдагдал 2015 онд 10 орчим хувьд хүрэх эрсдэлтэй байна. Монголбанкнаас олгож байгаа бүх бодлогын зээлүүд цаашид шинэ зээл олгохгүй буюу хуваарийн дагуу төлөгдөж, улмаар зогсох шаардлагатай бөгөөд хэрэв шаардлагатай бол төсөвт шилжүүлэх хэрэгтэй байна.

Эдийн засагт шаардлагатай байгаа зарим тохиргоо хийгдэх явцад өрхүүдэд ирэх сөрөг нөлөөлөл нэмэгдэх эрсдэлтэй бөгөөд энэ нь цаашид нийгмийн салбарт томоохон сорилтыг авчрахаар байна. Одоогийн нийгмийн халамжийн бодлого нь шилжилтийн ядуурлын асуудлыг шийдвэрлэх, илүү үр ашигтай нийгмийн хамгааллын зохих үйлчилгээг үзүүлэх чиглэлд хэрэгжих шаардлагатай байна. Энэ нь мэдээж төсөвт зорилтот бүлгийг чиглэсэн нийгмийн халамжийн зардалыг нэмэгдүүлэх байдлаар төсөвт ирэх ачааллыг нэмэгдүүлэх боломжтой.

**Монгол улс:** Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

	2012	2013	2014	2015 e	2016 f	2017 f
Дотоодын нийт бодит бүтээгдэхүүн	12.3	11.6	7.8	4.4	4.2	3.9
Хувийн хэрэглээ	13.3	14.1	10.6	7.0	8.3	9.1
Засгийн газрын хэрэглээ	18.5	15.2	-1.9	6.1	5.2	4.5
Нийт тогтмол капитал хөрөнгө оруулалт	14.7	-4.3	-33.5	8.2	43.6	2.6
Бараа материалын нөөцийн өөрчлөлт	31.5	22.8	7.6	7.3	7.1	6.9
Статистикийн зөрөө \ДНБ %\	89.0	17.2	0.0	0.0	0.0	0.0
Экспорт, бараа, үйлчилгээ	8.3	13.7	51.4	-2.9	-3.7	-4.6
Импорт, бараа, үйлчилгээ	15.4	6.3	4.9	1.0	16.6	0.9
ДНБ, зах зээлийн үнээр	12.3	11.6	7.8	4.4	4.2	3.9
Хөдөө аж ахуй	21.1	19.3	14.4	11.1	9.1	8.4
Аж үйлдвэр \уул уурхайг оролцуулан\	14.8	15.3	16.1	7.3	2.2	-0.6
Үйлчилгээ	10.3	6.8	4.8	2.4	4.4	6.1
Бүтээгдэхүүний зөрүү	0.8	2.5	2.9	0.4	-2.9	-5.8
Инфляцийн дундач	14.3	10.4	12.8	8.5	7.8	7.3
Урсгал дансний тэнцэл, ДНБ %	-27.4	-25.4	-8.2	-10.8	-19.0	-19.4
Төсвийн тэнцэл, ДХБ %	-9.1	-8.9	-11.0	-9.8	-6.4	-6.2
Ядуурлын хувь \Үндэсний ядуурлын түвшин\	27.4					
Хэрэглээний орлогын хуваарьлалт	33.8					